

## “ХОРИГДЛЫН ЯЛ ЭДЛЭХ ДЭГЛЭМ, ЗЭРЭГЛЭЛИЙГ ӨӨРЧЛӨХ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”

### THE CURRENT SITUATION OF CHANGING PRISON REGIMES AND CLASSIFICATIONS FOR INMATES



**Э.Өнөболд**

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, хошууч

Хууль зүйн магистр [Unubold4work@gmail.com](mailto:Unubold4work@gmail.com)

**Хураангуй:** Хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, гэмт этгээдийг засаж, залруулах, нийгмийн зөв иргэн болгон төлөвшүүлэхэд хорих ял эдлүүлэх ажиллагааны оролцоог дурдсан бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэхэд саад, бэрхшээл бий болгож буй хүчин зүйлсийг судлах тодруулахад чиглэсэн.

Судалгааг хууль зүйн шинжлэх ухааны эмпирик судалгааны аргуудыг ашиглахын зэрэгцээ онолын үзэл санааг практик үйл ажиллагаатай холбон тайлбарлах хүрээнд логик аналитикийн арга, хууль тогтоомжийн хийдлийг тодруулах хүрээнд системийн аргуудыг ашигласан.

Хоригдлын ял эдлэх дэглэм, зэрэглэлийг өөрчлөх ажиллагааны хууль зүйн хийдэл, үл нийцлийг илрүүлсэн.

**Abstract:** This study aims to enhance the social effectiveness of imprisonment by strengthening its role in rehabilitating offenders and transforming them into law-abiding citizens. It seeks to identify and analyze the key factors that hinder the effective implementation of imprisonment practices.

The research adopts a combination of empirical legal research methods and theoretical analysis, employing logical-analytical tools to bridge theoretical perspectives with practical operations. Furthermore, a systems-based approach was utilized to reveal legislative gaps and inconsistencies.

In particular, the study highlights significant legal ambiguities and contradictions within the procedures governing the modification of prisoners' incarceration regimes and classifications.

**Түлхүүр үгс:** Хүний эрх, хорих ял, цээрлэл, нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, дэглэм, зэрэглэл, хууль, эрх зүй, мөн чанар.

**Key words:** Human rights, Imprisonment or Custodial sentence, Punishment or Deterrence, Social reintegration or Socialization, Rehabilitation or Moral reformation, Regime, Classification, Law, jurisprudence, Essence.

## УДИРТГАЛ

Гэмт хэрэг хэмээх нийгмийн үзэгдэл хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг үеүдэд өөрийн гэсэн өнгө төрхтэйгөөр оршиж ирснийг бид олон эх сурвалжуудаас харж болно. Тухайн цаг хугацааны нийгмийн онцлог, соёлын ялгаа, хууль, эрх зүйн хэм хэмжээний жишиг зэргээс шалтгаалан гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдэд ял, шийтгэл оногдуулж ирсэн жишиг харилцан адилгүйгээр хувьсан өөрчлөгдөж ирсэн.

Энэ хугацаанд хүн төрөлхтөн гэмт хэрэгтэй тэмцэх арга бол ял шийтгэл болохыг таньж мэдсэн бөгөөд ял шийтгэлийн талаар олон янзын онол сургаалууд бий болон хөгжих ирсэн. Тэгвэл харьцангуй эрт үе ял шийтгэлийг илүү өшөө авах агуулгаар хэрэглэдэг байв. Үүнийг “Lex talion” (Horwitz, 2025) хэмээн нэрлэж байсан. Уг зарчмыг хамгийн анхлан эртний Вавилоны Хаммурапи хааны хууль тодорхойлсон бөгөөд тухайн нийгмийн шударга ёсны талаарх ойлголтыг тусгаж өгсөн байдаг. Тус хуулийн 196-д “Хэрэв язгууртан хүн өөр нэг язгууртан хүний нүдийг сохолбол түүний өөрийнх нь нүдийг сохолно” (Харари, 2017) хэмээсэн нь тухайн нийгэмд гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын зарчмыг тодорхойлж байна.

Үүнээс үзвэл гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага нь гэмт этгээдийг шийтгэх зорилгын хажуугаар нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх зорилго агуулж байсныг харж болохоор байна.

Түүнчлэн ял шийтгэлийн талаарх “Deterrence theory” буюу сэрэмжлүүлэх онол (Kant, 2025), “Rehabilitation theory” буюу засан хүмүүжүүлэх онол зэргүүд нь агуулгын хувьд бүгд л гэмт хэрэг үйлдсэн хүн шийтгэх ёстой гэсэн агуулгыг илэрхийлэх бөгөөд энэ нь нийгэм дэх шударга ёсыг хангах зорилготой болохыг онцолсон.

Тэгэхээр ял шийтгэл нь олон төрлийн онол сургаалууд нь нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх зорилгодоо хүрэх төрөл бүрийн арга, хэрэгслүүдийг тодорхойлж байгаа хэрэг болох тодорхой болж байна.

Харин орчин үед дэлхий нийтэд хорих ялаас татгалзан болсноор хорих ялыг илүү засан хүмүүжүүлэх агуулгыг илэрхийлэх ёстой гэж үзэж байгаа бөгөөд Penitentiary буюу хорих ял хорих байгууллагын зүй тогтлыг судалдаг шинжлэх ухааны салбараар тодорхойлох болсон. Хорих байгууллага нь засан хүмүүжүүлэх зорилгыг агуулах ба хорих ял эдэлж байгаа хүмүүст нөлөөлөх олон төрлийн нөлөөллийн арга, хэрэгслийг ашигладаг. Үүний нэг нь хоригдлын ял эдлэх дэглэм зэрэглэлийг өөрчлөх ажиллагаа бөгөөд Монгол Улсын хувьд хорих ял эдэлж байгаа хүмүүсийн дэглэм, зэрэглэл хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар авч үзлээ.

# I

Хоригдлын дэглэм зэрэглэлийг өөрчлөх ажиллагааны агуулгыг дурдахын өмнө мэдээжийн хэрэг хорих ялын зорилго, хорих ял эдлүүлэх дэглэмийн ойлголтыг тодруулах хэрэгтэй бөгөөд ингэснээр хоригдлын тодорхой дэглэмд хорих шаардлага болон тэрхүү дэглэмийг өөрчлөх ажиллагааг таньж мэдэх боломж бүрдэх юм.

Монгол Улсын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгыг “гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.” хэмээн тодорхойлжээ. (УИХ, Монгол Улсын Эрүүгийн хууль, 2016) Үүнд мөн л нийгэмшүүлэх зорилгыг тодорхойлсон бөгөөд хорих ял бол гэмт этгээдийг нийгэмшүүлэх үндсэн чиг үүрэгтэй ба нийгэмшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, нөхцөл журмыг агуулах ёстой гэсэн үг юм.

Харин НҮБ-ийн байгууллагын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм буюу Манделын дүрэмд хорих ял эдлүүлэх явдал нь хамгийн эцсийн арга бөгөөд хорих ял нь зөвхөн шийтгэх бус засаж хүмүүжүүлэх зорилготой болохыг анхааруулсан. (UNODC, 2015) Ингэснээр хорих ялыг үндсэн зорилго нь гэмт этгээдийг засаж хүмүүжүүлэх, нарийвчлан үзвэл нийгэмшүүлэх болохыг харж болно.

Тэгвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа уг зорилгод яв цав нийцэх ёстой бөгөөд хорих ял эдлүүлэх дэглэм нь хорих ялын зорилгыг гэмт этгээдийн онцлогт тохирсон байдлаар хэрэгжүүлэгч хэрэгсэл болдог.

Хорих ял эдлүүлэх дэглэм гэдгийг хоёр утгаар тайлбарлаж болох ба нэгдүгээрт “дэглэм” гэдэг нь хэл зүйн хувьд журам, зарчим, горим, дэглэм дагах-дэг ёс баримтлах, горим гүйцэтгэх, дэг дэглэм-хатуу ёс горим гэх зэргээр тодорхойлогдсон. (С.Бат-Эрдэнэ, 2008) Хоёрдугаарт засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад ял эдлүүлэх явцад ялтны дагаж мөрдөх бүх журам, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлж буй бүх арга хэмжээнүүд хамаарагдана” гэж бичсэн байна. (А.Лхагваа, 2012) Мөн доктор, профессор Н.А. Стручков “Хорих ял эдлүүлэх дэглэм гэдэг нь ял эдлэх, эдлүүлэх ажиллагааны хууль тогтоомжийн хэм хэмжээгээр зохицуулагдсан журам юм” гэжээ. Үүнтэй төстэй тодорхойлолтыг академич С.Нарангэрэл “Хорих ялыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад тогтоосон дэглэмийн нөхцөлд хангана. Дэглэмийн эрх зүйн мөн чанар нь засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээгээр тохируулан зохицуулагдсан ял эдлүүлэх журам байдгаар тайлбарлагдана” (С.Нарангэрэл, 1985), хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С. Жанцан, судлаач О. Энхбат нар “Хорих ял эдлүүлэх талаар засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад тогтоогдсон дэглэм гэдэг нь засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх

зүйн хэм хэмжээ болон бусад хуульчилсан актуудаар зохицуулагдан биеллээ олж байдаг. Нэг талаас засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаа, ажилтнуудын ял эдлүүлэх, нөгөө төлөөс ялтан ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад ягштал дагаж мөрдөх ёстой журмуудын нийлбэр бөгөөд ялтанг засан хүмүүжүүлэх дахин хүмүүжүүлэх үндсэн хэрэгслүүдийн нэг юм” гэж тодорхойлсон байна. (С.Жанцан, 1989)

Эдгээрээс үзвэл хорих ял эдлүүлэх дэглэм нь хорих ялын зорилгыг хангах, хорих ялыг залхаан цээрлүүлэх гэхээс илүүтэй хүмүүжилд нь нөлөөлөх хэрэгсэл болохыг илэрхийлсэн бөгөөд гагцхүү гэмт этгээдийн хувийн байдалд тохирсон байдлаар ялгагдах шаардлагатай болохыг дүгнэн үзэж болно.

Манай улсын хувьд нээлттэй, хаалттай дэглэмд хорих ялыг эдлүүлэх болоод өдгөө 8 дахь жилдээ зохион байгуулж байна. Өмнөх буюу 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хуулиар бид хорих ялыг жирийн, чанга, онцгой, гяндан гэсэн дэглэмийн төрлүүдэд авч үзэн хорих ялыг эдлүүлдэг байсан. Харин нээлттэй, хаалттай хорих ангийн хувьд өмнөх хорих ангийн дэглэмийн тогтолцооноос ялгагдах гол онцлог нь ялтныг сургах, байнгын тасралтгүй ажлын байраар хангах, ял эдлүүлэх орчин нөхцөлийг хүний эрхийг хангасан стандартын дагуу бүрдүүлэх зэрэг асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэж, хорих ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэхэд чиглэгддэг болохыг Монгол Улсын засгийн газрын хөтөлбөрт заажээ. (газар, 2013)

Тэгэхээр хорих ял эдлүүлэх дэглэмээр дамжин хоригдлыг нийгэмшүүлэх зорилго тодорхойлогдох нь харагдаж байна. Тэгвэл хорих ял эдлэх дэглэмийг өөрчлөн ажиллагааны зорилго ач холбогдол нь нийгэмшүүлэх ажлын нэг хэсэг болох нь дамжиггүй. Өмнө дурдсанчлан хорих ял гэмт этгээдэд нөлөөлөх хэрэгсэл бол тэрхүү нөлөөлөл нь хоригдлын сэтгэл зүй, хандлагад нөлөө үзүүлэх ёстой. Харин өнөөгийн хууль тогтоомжоор нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй ба хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно гэж заасан нь дэглэм өөрчлөгдөх нь хоригдлын эрх зүйн байдал, болон нийгэм, гэр бүлтэйгээ холбогдох боломжийг агуулсан ойлголт болжээ.

Ингэснээр хоригдолд ял эдлэх дэглэм хөнгөрөх нь эрх зүйн байдлыг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд дэглэм дээшлэх нь эрх зүйн байдлыг чангаруулж байгаа хэрэг юм. Энэ нь нэг талаас хорих ял эдэлж байгаа этгээдэд олгож буй урамшууллын нэг хэлбэр болох бөгөөд нийгэмших, хүмүүжих үйл явцад ахиц дэвшил гаргаж буй хоригдлыг урамшуулах, урам зориг нэмэхэд чиглэсэн механизм болох харагдаж байна. Нөгөө талаас ял эдлэх дэглэмийг дээшлүүлэх

буюу чангатгах нь хоригдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ болох бөгөөд хоригдолд сануулга, анхааруулга, зэмлэл болоход чиглэсэн арга хэмжээ юм. Ингэснээр хорих ял эдлэх дэглэмийг өөрчлөх нь хорих ялын зорилгыг хэрэгжүүлэхэд амин чухал арга хэмжээ болохыг мэдэх боломжтой бөгөөд хорих ялын уян хатан, хүний эрхийг хүндэтгэсэн байх агуулгыг илэрхийлж байна.

Гэхдээ өгүүллийн хүрээнд бид зэрэглэл хэмээх ойлголт ихээхэн дурдагдаж байгаа бөгөөд энэ нь манай улсын хорих ял эдлүүлэх ажиллагаанд шинээр орж ирсэн ойлголт болно. “Зэрэглэл” гэдгийг хэл зүйн хувьд авч үзвэл ангилал, дэс дугаарлал, зэрэглэл тогтоох гэсэн утгыг агуулна. Хорих ял эдлүүлэх ажиллагааны үүднээс үзвэл дэглэмд хоригдлын хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан ангилан хуваарилах ойлголтыг агуулж байна. Ингэж зэрэглэл тогтоох нь хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, ялыг ялгамжтай эдлүүлэх, хорих ялаас үүдэн бий болох сөрөг нөлөөллүүдийг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

Эрэгтэй, эмэгтэй хоригдлын онцлогоос хамааран хорих анги нь дараах дэглэм зэрэглэлтэй байгааг хүснэгтээр үзүүлье.

*Хүснэгт 1. Хорих ангийн дэглэм зэрэглэл*

| Эрэгтэй хоригдол    |                 | Эмэгтэй хоригдол    |                 |
|---------------------|-----------------|---------------------|-----------------|
| Нээлттэй хорих анги | Энгийн зэрэглэл | Нээлттэй хорих анги | -               |
|                     | Тусгай зэрэглэл |                     |                 |
| Хаалттай хорих анги | Энгийн зэрэглэл | Хаалттай хорих анги | Энгийн зэрэглэл |
|                     | Тусгай зэрэглэл |                     | Тусгай зэрэглэл |
|                     | Тусгай нэгж     |                     |                 |

Дээрх хүснэгтээс үзвэл эрэгтэй хоригдол нь нээлттэй, хаалттай хорих ангийн 5 зэрэглэлийн дотор ял эдлэх дэглэм зэрэглэлийг өөрчлөх боломжтой бол эмэгтэй хоригдлын хувьд нээлттэй, хаалттай дэглэмийн 3 зэрэглэлд ял эдлэх дэглэм, зэрэглэлийг өөрчлөх боломжтой байна. Эдгээр дэглэм, зэрэглэл бүр өөрийн онцлогт тохирсон байдлаар хоригдлын эрх зүйн байдлыг тодорхойлсон ба хоригдлыг хүмүүжихэд, хорих ял эдлүүлэх ажиллагааг үр дүнтэй болгоход чиглэгдэнэ.

Гэсэн хэдий ч энэхүү дэглэм зэрэглэл өөрчлөх ажиллагаанд хууль зүйн техникийн болон хууль хэрэглээний хэд хэдэн зөрчилдөөнтэй асуудал бий болоод байгааг уг өгүүллээр танилцуулъя.

## II

Хоригдлын дэглэм зэрэглэлийг өөрчлөх ажиллагаа дахь зөрчилдөөнтэй агуулгуудыг дурдахын өмнө эрүүгийн хуульд хоригдлын ял эдлэх дэглэм зэрэглэлийг хэрхэн тодорхойлсныг анхаарах хэрэгтэй бөгөөд учир эрүүгийн хууль бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх материаллаг үндэс

болно. Нэг үгээр бол процессын хууль болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн агуулга нь эрүүгийн хуулийн агуулгатай яв цав нийцэх ёстой гэсэн үг.

“Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ.”, “шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно.”, “хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ.” хэмээн тус тус авч үзсэн нь хорих ялыг эдлүүлэх дэглэмийн агуулга, зорилтыг тодорхойлжээ. (УИХ, Эрүүгийн хууль, 2016) Үүнээс үзвэл хаалттай хорих байгууллага нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн болон эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргийг үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, хор уршиг, хувийн байдлын хувьд харьцангуй хүнд хүмүүсийг хорих агуулгыг илэрхийлж байна.

Тэгэхээр хорих ял эдэлж байгаа хүмүүсийн ял эдлэх дэглэмийг дээшлүүлэх ойлголт нь нээлттэй дэглэмд ял эдэлж байгаа хоригдлын хувийн байдал нь нээлттэй хорих байгууллагад хоригдох боломжгүй болсноор тайлбарлагдах бол дэглэмийг буулгаж байгаа ойлголт нь хаалттай дэглэмд ял эдэлж байгаа хоригдлын хувийн байдал хаалттай хорих ангид ял эдлүүлэх шаардлагад нийцэхгүй буюу засарч хүмүүжиж байгаа эсхүл, нийгэмшиж байгаа түшингээр тодорхойлогдох ажээ. Энэ утгаар нь авч үзвэл хоригдлын ял эдлэх дэглэм зэрэглэлийг өөрчлөх ажиллагаа нь хүний эрхийг хангасан, ял шийтгэлийг шударга эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болохыг харж болно.

Хоригдлын ял эдлэх дэглэм зэрэглэлийг бууруулахдаа тухайн хуваарилагдсан дэглэм дотор нь ял эдлэх зэрэглэлийг хөнгөрүүлэх болон хаалттай дэглэмээс нээлттэй дэглэмд шилжүүлэн ял эдлүүлэх байдлаар зохицуулж байна. (УИХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017) Энэ талаар тус хуулийн 206 дугаар зүйлд нийт 11 арга журмын хүрээнд тодорхойлсон ба эрүүгийн хуульд заасан агуулга ёсоор нээлттэй дэглэмийн хуваарилагдсан зэрэглэлээс болон хаалттай хорих ангийн хуваарилагдсан зэрэглэлд тодорхой хугацааны ял эдлээд зохих шаардлага хангасан бол тухайн дэглэм дотроо зэрэглэл хөнгөрч болох заасан. Мөн 206 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт Сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, сахилга, засрал хүмүүжлийн байдлаараа эерэг үнэлгээ авсан нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлыг хорих ялын хугацаа дуусахаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлнэ гэсэн нь хаалттай хорих ангиас дэглэм хөнгөрч ял эдэлж байгаа хоригдолд хамаарах асуудал болохыг харуулж байна. Гэсэн ч энэхүү агуулгыг тодруулж өгөөгүйн улмаас нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд хорих ял эдэлж байгаа хоригдол 2 өөр үндэслэлээр ял эдлэх зэрэглэлээ хөнгөрүүлж болох буруу ойлголтыг төрүүлж байна.

Энэ бол хоригдлын ял эдлэх зэрэглэлийг хөнгөрүүлэхэд тохиолдож нэгдүгээр бэрхшээл юм.

Дараагийн хэсэгт хуульд зааснаар хаалттай хорих ангийн хоригдлыг нээлттэй хорих ангид шилжүүлэн ял эдлүүлэх агуулгыг заасан хэдий ч хоригдлыг заавал хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлсний дараагаар нээлттэй хорих ангид дэглэм буулгах асуудлыг хорих ял эдлүүлэх ажиллагааны практикт хэрэглэж байна. Гэтэл хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээнүүдэд хоригдлыг заавал шатлан буулгах зарчим баримтлах талаар заасан, тусгасан зохицуулалт алга байна.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт хүндрүүлэн шилжүүлсэн дарааллын дагуу анх хуваарилагдсан зэрэглэлд зэрэглэл хөнгөрүүлэх агуулгыг гуйвуулан хэрэглэж байна гэж үзэж байна.

Учир нь хууль тогтоомж бол эрх, үүргийг тогтоох замаар боломжит хязгаарлалтыг тогтоох замаар нийгмийн харилцааг зохицуулдаг зарчимтай. Гэтэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа, тэр дундаа хорих ял эдлүүлэх ажиллагаанд зөвшөөрснөөс бусдыг хориглох зарчим баримталж байгаа нь эрх зүйн хэм хэмжээний хийдэл үүсэх, хүний эрхийг хуульд зааснаас өөрөөр хязгаарлаж байгаа хэрэг юм.

Гуравдугаарт тулгамдсан асуудал нь хорих ял эдэлж байгаа хоригдлын дэглэм, зэрэглэлийг дээшлүүлэхэд бий болж байна.

Дээр өгүүлснээр эрүүгийн хуульд нээлттэй, хаалттай гэсэн хоёр дэглэмийг зааж өгсөн. Энэ бол материаллаг хуулиар хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн хоёр дэглэм байна гэсэн агуулгыг тодорхойлсон хэрэг. Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хаалттай хорих анги нь энгийн, тусгай зэрэглэлтэй байна гэж заасан ба тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна гэжээ. (УИХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017) Эдгээр зохицуулалт нь хаалттай хорих анги нь хоёр л үндсэн зэрэглэлд хуваагдах агуулга маш ойлгомжтой заасан ба энэ нь мөн хуулийн 201 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тусгай нэгжтэй байна.” буюу хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн тусгай нэгж болон сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын тусгай нэгж нь онцгойлон анхаарах шаардлагатай болон тусгай хяналтын дэглэм бүхий хүмүүсийг хориход чиглэсэн тухайн дэглэм, зэрэглэл дэх тусгай хорих салбар болохоор ойлгогдож байна.

Нэг үгээр бол дээрх нь хэвтээ шугамд ижил түвшинд хамаарах зэрэглэл юм. Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн хувьд ч тэр, сургалт хүмүүжлийн тусгай зэрэглэлийн хувьд ч мөн адил.

Гэтэл хоригдлын ял эдлэх дэглэм, зэрэглэлийг чангаруулах буюу хоригдолд хэрэглэх анхааруулга, сануулга өгөх хэрэгслийг ашиглахдаа хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн тусгай нэгжийг тусгай зэрэглэлийн дээр буюу босоо шатлалд авч үзэж байгаа нь хуулийн логик зүй тогтол, системчилсэн байх хууль зүйн техникийн шинжлэх ухааны шаардлагыг үгүйсгэж байна. Яг үүнтэй зэрэгцэн мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жилийн ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлэх тухай асуудлыг прокурор шийдвэрлэхээр байгаа нь хаалттай хорих ангийн тусгай нэгж бол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд хамаарах тусгай салбар болохыг баталж байна. Ийм атал тусгай зэрэглэлд хамаарах нэг салбарын хоригдлын эрх зүйн байдлыг ялгамжтай тогтоож, тэнд хоригдох хоригдлын эрх зүйн байдлыг дордуулж байгаа нь хууль хэрэглээний томоохон алдаа юм.

Үүнийг дурдсан гол санаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох зарим заалтууд нь хоорондын хийдэл, үл нийцэл ихтэй байгааг онцолж байгаа бөгөөд харин хууль хэрэглэхдээ хоригдлыг цээрлүүлэх шийтгэх агуулга, үзэл санаанд чиглэгдэн хэрэгжүүлж байгааг тэмдэглэхэд чиглэсэн юм. Учир нь эрх зүй бол эрхүүдийг зохистой хослол, нийлэмжийг судалдаг шинжлэх ухааны салбар бөгөөд зөвхөн хуулиар л эрхийг хязгаарлах зарчмыг номлодог. Гэтэл хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад хуульд бий болсон хийдэл, давхардсан ойлголт нь хоригдлын эрх зүйн байдлыг дордуулах шалтгаан болж байгаа нь хүний эрхийн хийгээд, хууль зүйн техникийн зөрчил гэж үзэж байгааг энэхүү өгүүллээрээ хүргэж байна.

Хүснэгт 2. Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн тусгай нэгжийн мөн чанар.

| Хаалттай хорих ангийн тусгай нэгж болон сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын тусгай нэгж бол ижил |                 |                                                                                             |                                                  |                 |
|-----------------------------------------------------------------------------------------------------|-----------------|---------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|-----------------|
| ШШГТХ-ийн үзэл санаа, заалтын гол агуулга нь                                                        |                 | Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага                                                       | Гэтэл хоригдлын дэглэм зэрэглэлийг дээшлүүлэхдээ |                 |
| Хаалттай дэглэм                                                                                     | Тусгай зэрэглэл | Өсвөр насны эрэгтэй хоригдол<br><br>Тусгай нэгж<br><br>Өсвөр насны эмэгтэй хоригдлыг хордог | Хаалттай дэглэм                                  | Тусгай нэгж     |
|                                                                                                     | Тусгай нэгж     |                                                                                             |                                                  | Тусгай зэрэглэл |
|                                                                                                     | Энгийн зэрэглэл |                                                                                             |                                                  | Энгийн зэрэглэл |
| Нээлттэй дэглэм                                                                                     | Тусгай зэрэглэл |                                                                                             | Нээлттэй дэглэм                                  | Тусгай зэрэглэл |
|                                                                                                     | Энгийн зэрэглэл |                                                                                             |                                                  | Энгийн зэрэглэл |

Уг хүснэгтээс үзвэл хууль тогтоомжийн нэр томьёо нь ойлгомжтой, нэг мөр ойлгогдож хэрэглэгдэх ёстой атал, тэрхүү чанараа алдсанаас үүдэн хууль хэрэгжүүлэх ажиллагаанд логикийн алдаатай, системгүй хууль хэрэглээ ба хийдэл үүсч байгааг эрх зүйт төрийн эрхэмлэгчид бид анхаарах ёстой.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Өгүүллийн хүрээнд дараах дүгнэлтүүдийг дэвшүүлж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны цээрлэл нь иргэний эрхийг хязгаарлаж, тодорхой дэглэм байгууллагад хорьсноор биеллээ олдог бөгөөд уг шинжээс бусад цээрлэлийн шинжтэй арга хэрэгсэл нь хуульд зааснаар өөрөөр хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгаа хэрэг юм.

Уг агуулгаар Эрүүгийн хууль, тогтоомж болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт, шинэтгэл хийсэн. Гэсэн хэдий ч хуулийн төсөл боловсруулах, хууль хэрэгжүүлэх ажиллагааны тодорхой хэсгүүдэд хүний эрх, эрхэм чанарыг агуулгыг гажуудуулсан, Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчим, эрх зүйн онолын зарчим шаардлагуудыг бүрэн дүүрэн судлаагүйгээс хүний эрхийг хангасан, үр дүнтэй хорих ял эдлүүлэх ажиллагааны зарим үндсэн үзүүлэлтүүд алдагдсан байна.

Монгол Улсын эрүүгийн ялын бодлого нь Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцын хүрээнд дотоод эрх зүйн хэм хэмжээний агуулаг өөрчлөгдсөн хэдий ч үзэл баримтлалын хүрээнд бус хэлбэрийн өөрчлөлтүүдийг тусгасан болохыг харж болохоор байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх зорилгодоо хүрэхэд чиглэсэн олон арга хэмжээг уялдуулан ажиллуулдаг хэдий ч тодорхой арга хэмжээний ажиллагаа нь орчин үеийн хүний эрхийн болон ял эдлүүлэх ажиллагааны чиг хандлага, үндсэн зорилтод нийцэхгүй байна гэж дүгнэж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн агуулга, найруулга нь хууль зүйн техникийн зөрчлүүдийг өөртөө агуулж байна. Ингэснээр хорих ял эдлүүлэх ажиллагаа дахь хоригдлын ял эдлэх дэглэм, зэрэглэлийг өөрчлөх хэмээх хоригдолд хүмүүжил болон нийгэмд эргэн нэгдэхэд чухал нөлөөтэй арга хэмжээ чанаргүй хэрэгжихэд хүрч байна.

Эдгээр нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго, чиг хандлага хүний эрхийн агуулгаар тодорхойлогдож, хорих ял эдлүүлэх байгууллагын тогтолцоог нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулсан хэдий ч хууль тогтоомжийн хийдэлтэй байдал эрх зүйн хэм хэмжээний хүчин чадал үйлчлэлийг сулруулж, хорих ялын гэмт этгээдийг засан хүмүүжүүлж, нийгэмд эргэн нэгтгэх мөн чанарыг алдагдуулж байна.

Иймд өгүүллийн хүрээнд дараах саналуудыг гаргаж байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206, 226 дугаар зүйлүүдэд өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулах.

2. Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн тусгай нэгжид тавигдах шаардлага, дэглэм, зэрэглэлийн онцлог ялгааг хуульд өргөжүүлэн тусгах.

3. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хорих зориулалт бүхий тусгай нэгжид ял эдлэх дэглэм, зэрэглэл дээшилсэн хоригдлыг хамт хорих практикийг арилгах.

4. хуульд заасан ижил нэр томьёо нь ижил утгаар хэрэглэгддэг байх ёстой бөгөөд өөр, өөр агуулга, зорилгоор хэрэглэгдэх тохиолдолд томьёоллыг өөрчилж ялгаатай байдлаар нэрлэх шаардлагатай зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

Horwitz, A. X. (2025). Oxford Reference. Retrieved from Oxford University press: <https://www.oxfordreference.com/>

Kant, I. (2025). Cambridge Core. Retrieved from Cambridge University press: <https://www.cambridge.org/>

UNODC. (2015). The United Nations Standard Minimum Rules for the Treatment of Prisoners. Vienna: Vienna International Centre.

А.Лхагваа. (2012). Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. Улаанбаатар: Тоонот принт.

газар, М. У. (2013). Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7.

С.Бат-Эрдэнэ, Э. (2008). Монгол хэлний тайлбар толь . Улаанбаатар: Бемби сан.

С.Жанцан. (1989). Хорих ял эдлүүлэх дэглэм, түүний хангах хэрэгсэл. Улаанбаатар .

С.Нарангэрэл. (1985). БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх эрх зүйн үндсэн асуудал . Улаанбаатар .

УИХ. (2016). Монгол Улсын Эрүүгийн хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7.

УИХ. (2016). Эрүүгийн хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7.

УИХ. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл , №24.

Харари, Ю. Н. (2017). Sapiens. Улаанбаатар : Мон Судар.

---o0o---